



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/А

Улаанбаатар хот

Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг  
болон мэргэжлийн ур чадварыг хадгалах  
журмыг батлах тухай

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын баримт бичиг /DOC9756, P1/-ийн 2.4.2, 2.4.3 дахь заалт, Зам, Тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 298 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг болон мэргэжлийн ур чадварыг хадгалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүү, Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа) нарт тус тус даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



## ШИНЖЛЭН ШАЛГАГЧ НАРЫН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ БОЛОН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журам нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ийн баримт бичиг /DOC9756, P1/-ийн 2.4.2, 2.4.2 дах заалт болон Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулга, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 298 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26. заалтыг тус тус үндэслэн боловсруулагдсан.

1.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгагч нар нь мэргэжлийн ур чадварыг хадгалах дараах сургалт дадлагат хамрагдсан байна. Үүнд:

- 1.2.1. анхан шатны сургалт
- 1.2.2. ажлын байран дээрх сургалт
- 1.2.3. Шинжлэн шалгах ажиллагааны шинжлэн шалгагчийн үндсэн сургалт
- 1.2.4. Шинжлэн шалгах ажиллагааны тусгай сургалт
- 1.2.5. Хурал семинар
- 1.2.6. Шинжлэн шалгах ажиллагаанд ажиглагчаар оролцох
- 1.2.7. Суурь мэргэжил /нисгэгч, инженер, нислэгийн хөдөлгөөний удирдагч/-ийн сургалт дадлага, мэргэшлийн зэрэг хадгалах;

1.3. Энэ журмын 1.2.7-д заагдсан сургалт, дадлагаас бусад сургалтыг албаны “Aircraft Accident Investigation Policy and Procedures Manual” /Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах бодлого, үйл ажиллагааны заавар /-ийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.4. Шинжлэн шалгагч нарын суурь мэргэжил /нисгэгч, инженер, нислэгийн хөдөлгөөний удирдагч/-ийн мэргэшлийн зэрэг болон сургалт дадлагыг энэ журмаар зохицуулна.

### ХОЁР. УР ЧАДВАР БОЛОН МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ХАДГАЛАХ

2.1. Энэ журмын 1.2.7-д заагдсан нислэгийн удирдлагын шинжлэн шалгагчийн мэргэшлийн зэргийг Иргэний нисэхийн үндэсний төвийн захирлын “Нислэгийн хөдөлгөөний удирдагчид мэргэшлийн зэрэг олгох журам” болон ур чадвар хадгалах сургалтыг “Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан “Нислэгийн

удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн ур чадвар хадгалах журам"-ын дагуу хэрэгжүүлж болно.

2.2. Техникийн шинжлэн шалгагчийг шаардлагатай гэж үзвэл мэргэшлийн зэрэг болон суурь мэргэжлийн ур чадвар /инженер/-ийг хадгалах зорилгоор түүний өмнө нь эзэмшсэн агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийн шилжин сургалтанд суралцуулж болно.

2.3. Техникийн шинжлэн шалгагчийг агаарын хөлгийн үйлдвэрлэгчдээс зохион байгуулж байгаа холбогдох хурал семинарт оролцуулах

2.4. Хэрэв шинжлэн шалгагч нь нисгэгчийн мэргэжлийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй тухайн төрлийн агаарын хөлгөөр нислэг үйлдэж байгаа бол түүний нислэгийн ур чадварыг алдагдуулахгүй байх шаардлагатай.

2.5. нислэгийн шинжлэн шалгагч нь нислэгийн ур чадвараа хадгалах нислэг үйлдэхдээ иргэний нисэхийн холбогдох дүрэм, тухайн компанийн нислэгийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, зааврын дагуу гүйцэтгэнэ.

2.6. Нислэгийн шинжлэн шалгагч нь тухайн төрлийн агаарын хөлгийг эзэмшигч, ашиглагч байгууллагын эрх бүхий этгээдтэй хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр нислэгийг үйлдэнэ.

2.7. Нислэгийн шинжлэн шалгагчийн суурь мэргэжлийн ур чадварыг хадгалах зорилгоор хийгдэж байгаа нислэгийг үндсэн ажлын цагийн нөхцөл байдалд уялдуулан ахлах шинжээч зохион байгуулж ажиллана.

2.8. Нислэгийн шинжлэн шалгагч нь өөрийн эзэмшсэн агаарын хөлгөөр сард 20 хүртэл цагийн нислэгийг үйлдэж болно.

2.9. Нислэгийн шинжлэн шалгагчийн нислэг үйлдсэн цагийг төрийн болон хувийн агаарын тээврийн компаниудын нислэгийн удирдлагуудын нэгэн адил ажилласан цагт тооцож бүртгэнэ.

2.10. ахлах шинжлэн шалгагч нь нислэг үйлдэгч шинжлэн шалгагчийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиг сонирхолын зөрчилд орохгүй байх нөхцөл боломжоор хангаж, хяналт тавьж ажиллана.

2.11. Нислэгийн шинжлэн шалгагч нь нислэгт явах өдрийг урьдчилан мэдэгдэх бөгөөд захиргааны менежер нислэгийн цагийн хэтрэлтэнд хяналт тавина.

2.11. Нислэг үйлдэж байгаа шинжлэн шалгагч нь Иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу жил бүрийн эрүүл мэндийн үзлэг болон нислэгийн шалгалт, дадлагжуурт хамрагдаж байна.

## ГУРАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ БОЛОН СУРГАЛТ ДАДЛАГЫН ЗАРДАЛ ОЛГОХ

3.1 Энэ дүрмийн 2.1-д заагдсан мэргэшлийн зэргийн нэмэгдэлийг Иргэний нисэхийн үндэсний төвийн захирлын “Нислэгийн хөдөлгөөний удирдагчид мэргэшлийн зэрэг олгох журам” –ын дагуу олгоно.

Үүнд: Мэргэшлийн I-р зэрэг -20%

Мэргэшлийн II-р зэрэг -15%

Мэргэшлийн III-р зэрэг -10%

3.1. Энэ дүрмийн 2.1, 2.2, 2.3. заагдсан сургалт дадлагын зардлыг нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны зардлын төсөвт тусгуулан хэрэгжүүлэнэ.

3.2. Нислэгийн шинжлэн шалгагчийн үйлдвэрлэлийн нислэгт оролцсон цалин болон энэ журмын 2.11-д заагдсан үзлэг, дадлагын зардлыг нислэг үйлдэж байгаа байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн байгууллагын зардалд тусгаж хэрэгжүүлнэ.